

**“ХӨВСГӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019-04-29

Мөрөн.

Хурал: Хөвсгөл аймаг Мөрөн сумын 8-р багт байрлах “Хөвсгөл Хүнс”ХК-ийн өөрийн хурлын зааланд 2019 оны 04-р сарын 29-ны өдрийн 17.00 цагт эхлэв.

Хурлын ирцийг “Хөвсгөл Хүнс” ХКомпанийн ТУЗ-ийн Хурлын дарга Л.Дашцэрэн ирцийг 85.7 хувь байгааг мэдэгдэж хурлыг нээж.

Хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцуулав.

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг батлах
- Хянан шалгах зөвлөлийн тайлан
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Ногдол ашиг тараах эсэх

Хурлын дарга Л.Дашцэрэн- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулав.

Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

Гүйцэтгэх захирал Л.Цэрэнжав- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан

- Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлэв.

Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр - Хянан шалгах зөвлөлийн тайлан

- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Ногдол ашиг тараах эсэх асуудлыг хэлэлцүүлж санал хураалт явуулав.

2018 оны жилийн эцэст ашигтай ажилласан тул нэгж хувьцааны ашгийг 10 төгрөгөөр тооцон ногдол ашиг хувиарлахаар болсон.

За дээрхи асуудлуудтай холбоотой санал хүсэлт байна уу?

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Ж.Алтангэрэл-
Тооллогын комиссын дүнг танилцуулав.

Хурлын дарга Л.Дашцэрэн- Тооллогын комиссын дүнг үндэслэн тогтоолын
төслүүдийг батлуулж уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал- Л.Цэрэнжав - 2018 онд талх нарийн боовны сав баглаа
боодлыг шинэчлэн сайжруулж шинэ савлагаатай болголоо. Ингэснээр нарийн
боовны өнгө үзэмж сайжирч хэрэглэгчийн худалдан авах түвшинд дээшилсэн.
2019 онд компаний ашиг орлогыг нэмэгдүүлж ажиллуулах тал дээр анхаарч бизнес
төлөвлөгөөнд зарим зүйлүүдийг тусгасан.

Мөн нөөшилсөн бүтээгдэхүүний цехийн тасралтгүй ажиллагааг хангах жилийн
дөрвөн улиралд үйлдвэрлэл явуулдаг байх адуу үхрийн мах нөөшлөх хатаах зэрэг
бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зах зээлд нэвтрэх тал дээр анхаарч
ажиллаж байна. Манай компани нь 2019 онд сургууль цэцэрлэгийн 100 гаруй сая
төгрөгийн тендерт шалгараад байна. Мөн энэ 6-р сард багтаан Хөвсгөл нуурын
хаянд Хатгал тосгонд цэвэр усны үйлдвэрийг ашиглалтад оруулахаар ажиллаж
байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 18.10
минутад хаав.

ТАНИЛЦСАН: ТУЗ-ИЙН ДАРГА

Л.ДАШЦЭРЭН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

С.ОТГОНБААТАР

